



TALIIN ERDES LLC

ТАЛЫН ЭРДЭС ХХК

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН НУТАГТ
ОРШИХ MV-020902 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТАЛБАЙ БҮХИЙ “ШИРЭН-ОВОО” НЭРТЭЙ
ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026 он

АГУУЛГА

АГУУЛГА 2

БҮЛЭГ 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	5
1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ.....	5
1.3 ОРДЫН НӨӨЦ.....	6
1.4 ИЛ УУРХАЙ.....	7
1.4.1 Ил уурхайн процесс	7
1.4.2 Тэсэлгээний ажил.....	7
1.4.3 Үйлдвэрлэлийн нөөц хаягдал, бохирдол.....	7
1.4.4 2026 оны уулын ажлын төлөвлөлт	8
1.4.5 Техник, тоног төхөөрөмж зохион байгуулалт	9
1.5 ХҮДЭР БОЛОВСРУУЛАЛТ, БАЯЖМАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ	10
1.5.1 Баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөө.....	10
1.5.2 Хуурай соронзон баяжуулах үйлдвэрийн техник тоног төхөөрөмж	11
1.6 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	11
1.6.1 Ил уурхайн байгууламж	12
1.6.2 Овоолго.....	12
1.6.3 Зам тээвэр	13
1.6.4 Тэсрэх материалын агуулах	14
1.6.5 Засварын газар.....	15
1.6.6 Түлшний зөөврийн агуулах, түгээх станц.....	15
1.6.7 Гаалийн талбай	15
1.6.8 Автопүү	15
1.6.9 Чанарын хяналтын лаборатори.....	15
1.6.10 Ажилчдын амрах байр	16
1.6.11 Харуулын байр	16
1.6.12 Далан шуудуу, галын зурвас байгууламж.....	16
1.6.13 Салхинаас хамгаалах хаалт	17
1.7 ДЭД БҮТЭЦ.....	17
1.7.1 Цахилгаан хангамж	17
1.7.2 Дулаан хангамж.....	17
1.7.3 Усан хангамж	17
1.8 ТӨСЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН	
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	18
2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ	18
2.2 ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ	18

2.3	АГААРЫН ЧАНАР	18
2.4	ФИЗИК БОХИИРДОЛ.....	19
2.5	ГАДАРГЫН УС БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС	19
2.6	ХӨРСӨН БҮРХЭВЧ	19
2.7	УРГАМЛАН НӨМРӨГ	20
2.8	АМЬТНЫ АЙМАГ	20
2.9	НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	21
БҮЛЭГ 3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ		22
3.1	АГААРЫН ЧАНАР	22
3.2	УСАН ОРЧИН	22
3.3	ХӨРСӨН БҮРХЭВЧ	22
3.4	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ	22
3.5	НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ	23
БҮЛЭГ 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ		24
4.1	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
4.2	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
4.3	ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН	34
4.4	НҮҮЛГЭН СУУРЬШУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
4.5	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
4.6	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	37
4.6.1	Олдвор илэрсэн үед мөрдөх дараалал.....	38
4.6.2	Хориглох үйл ажиллагаа	39
4.6.3	Бүрдүүлэх баримт бичиг	39
4.6.4	Хүлээгдэж буй үр дүн	39
4.7	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	40
4.8	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	42
4.9	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	44
4.9.1	Байгаль орчны аудит.....	45
4.10	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	45
4.11	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	53

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Төслийн талбайн солбилцлын цэгүүд.....	6
Хүснэгт 1-2. Ил уурхайн процессын дараалал.....	7
Хүснэгт 1-3. 2026 онд ашиглалтад өртөх үйлдвэрлэлийн нөөцийн блокууд.....	8

Хүснэгт 1-4. 2026 оны уулын ажлын төлөвлөлт.....	8
Хүснэгт 1-5. Технологийн замын үндсэн үзүүлэлт	13
Хүснэгт 1-6. Тэсрэх материалын агуулахын үзүүлэлт	14
Хүснэгт 4-1. 2026 оны БОМТ-ын зардлын хураангуй.....	24
Хүснэгт 4-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 1-2. Тарих модны төлөвлөгөө (Тэрбум мод)	34
Хүснэгт 1-3. Хэрэгжүүлэх арга хэмжээ	37
Хүснэгт 1-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	40
Хүснэгт 1-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	43
Хүснэгт 1-6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	44
Хүснэгт 1-7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, Дотоод хяналт шинжилгээгээр...	46
Хүснэгт 1-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, Хөндлөнгийн хяналт шинжилгээгээр	48
Хүснэгт 1-9. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	53

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн талбайн байршил	6
Зураг 1-1. Орчны хяналт мониторингийн цэгүүд.....	52

БҮЛЭГ 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Ширэн-Овоо” нэртэй Төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах
Аж ахуйн нэгж байгууллага:	Талын Эрдэс ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011492106
Регистрийн дугаар:	5857872
Хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннүгийн гудамж, May seven оффис, 17 давхар 1706 тоот
Утас:	+976 88331166, 88115509
Цахим шуудан:	taliinordesllc@gmail.com

"Талын Эрдэс" ХХК нь 2017 онд байгуулагдсан бөгөөд Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших "Ширэн-Овоо" нэртэй төмрийн хүдрийн орд бүхий талбайд "MV-020902" тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг болно.

Манай компани нь 1,745.74 га талбай бүхий тусгай зөвшөөрлийн талбайг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоол, 2015 оны 511 дүгээр тогтоол, Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1, 24.2, 26.9, 49.7, 60.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн Ашигт малтмалын газраас 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зарласан сонгон шалгаруулалтад оролцож, хууль тогтоомжийн дагуу авсан.

Тус талбайд 2016 онд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэн, "Ширэн Овоо" нэртэй төмрийн хүдрийн ордын нөөцийг 2017 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Ашигт малтмал, газрын тосны газраар батлуулсан. Улмаар тухайн онд Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 532 дугаар шийдвэрээр MV-020902 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон бүртгүүлсэн.

"Ширэн Овоо" төслийн Техник эдийн засгийн үндэслэлд тодотгол хийн Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн №Т/116 тоот тушаалаар батлуулсан бөгөөд тус газарт 2026 оны Уулын ажлын төлөвлөгөөг хүргүүлэн батлуулсан.

1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Тусгай зөвшөөрлийн талбай нь физик газар зүйн мужлалаар Халх–Нөмрөгийн сав нутаг, Говь–Хянганы уулархаг бүсэд хамаарах бөгөөд уур амьсгал, ургамалжилт, амьтны аймгийн хувьд өвөрмөц онцлогтой нутаг дэвсгэрт оршино.


Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн тийш 1,067 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн урагш 448 км, Халхгол сумын төвөөс зүүн урагш 70 км, Монгол Улсын Сүмбэр боомтоос баруун тийш 10 км зайд байрладаг. Тусгай зөвшөөрлийн талбай нь зүүн урд талаараа “Зэст Өндөр” ХХК-ийн эзэмшлийн MV-016660 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай хиллэдэг бөгөөд баруун, баруун урд, хойд болон зүүн хойд талаараа бусад тусгай зөвшөөрлийн талбайтай хиллэдэггүй.

Төслийн талбай нь Буйр нуур–Халх голын сав газарт хамаарах боловч гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын болон ойн сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүстэй давхцалгүй болно.

Төслийн талбайн булангийн солбицлын цэгүүд, байршлын зургийг доор тус тус тусгав.

Хүснэгт 1-1. Төслийн талбайн солбилцлын цэгүүд

№	Уртраг (E)	Өргөрөг (N)	Нийт талбайн хэмжээ
1	119°22'02.99" E	47°17'32.19" N	1,745.74 га
2	119°20'00.00" E	47°17'32.19" N	
3	119°20'00.00" E	47°20'00.00" N	
4	119°24'02.99" E	47°20'00.00" N	
5	119°24'02.99" E	47°18'47.19" N	
6	119°22'02.99" E	47°18'47.19" N	



Зураг 1-1. Төслийн талбайн байршил

1.3 ОРДЫН НӨӨЦ

Ширэн Овоогийн төмрийн хүдрийн ордод 2016 онд эрэл, хайгуул, нарийвчилсан хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэн 2 хүдрийн биет бүхий бодитой В болон боломжтой С зэрэглэлээр нийт 14 сая тонн нөөцийг тогтоож, ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

Уурхайн нээлт, +981 метрийн түвшинд хүдэр олборлолт, баяжуулалтын үйлдвэрийн туршилтын ажлыг 2023 онд гүйцэтгэж явуулсан.

2023 онд нийт 87.54 мянган тонн хүдэр олборлосноос 36.5 мянган хүдрийг зэрэгцээ тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй Зэст Өндөр ХХК-ийн хуурай аргын баяжуулах үйлдвэрт баяжуулж, үйлдвэрлэлийн туршилтыг явуулснаар 19.5 мянган тонн баяжмал үйлдвэрлэсэн бөгөөд үүнээс 5.6 мянган тонн баяжмалыг экспортолсон байна.

2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар уурхайн талбайд олборлосон 51.0 мянган тонн хүдэр, 13.93 мянган тонн баяжмалын үлдэгдэл байна.

Ордын геологийн үлдэгдэл нөөц 13.93 сая тонн бөгөөд үүнээс ашиглалтын нөөцийг 10.9 сая тонноор тооцож, ил уурхайн ашиглалтын хугацааг нийт 12 жилээр төлөвлөсөн. Энэ хугацаанд нийт 17.4 сая м³ хөрс хуулж, хаягдал болон бохирдлыг тооцсоны дараа 10.82 сая тонн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгасан бөгөөд хүдрийн хаягдлыг 4.82 хувь, бохирдлыг 4.16 хувиар тооцсон байна.

Уурхай нь жилд 365 хоног тасралтгүй ажиллаж, жилд 1.0 сая тонн хүдэр олборлох хүчин чадалтай байна. Харин уурхайн үйл ажиллагаа 2026 оны 7 дугаар сараас эхлэх тул ашиглалтын эхний жилд нийт 184 хоног ажиллаж, 500.0 мянган тонн хүдэр олборлохоор төлөвлөсөн. 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлосон хүдрийг хуурай соронзон баяжуулалтын технологиор боловсруулж, төмрийн 52 хувийн агуулгатай 194.1 мянган тонн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

1.4 ИЛ УУРХАЙ

1.4.1 Ил уурхайн процесс

Ордын уул-геологи болон уул-техникийн нөхцөлтэй уялдуулан гадаад овоолготой, автотээвэр бүхий ашиглалтын системээр олборлолтын үйл ажиллагааг явуулна.

Ил уурхайн уулын үйлдвэрлэлийн үндсэн процесс нь чулуулгийг ухаж ачихад бэлтгэх, ухаж ачих, тээвэрлэх болон овоолох үе шатуудаас бүрдэнэ. Шимт хөрсийг түрэгч техникээр хуулж, тусгайлан бэлтгэсэн шимт хөрсний овоолгод байршуулна. Үндсэн хөрсийг өрөмдлөг, тэсэлгээний ажлаар бутлан сийрэгжүүлсний дараа экскаватороор ухаж ачин, автотээврээр хөрсний гадаад овоолгод тээвэрлэн байршуулна. Хүдрийг мөн өрөмдлөг, тэсэлгээний аргаар бутлан сийрэгжүүлж, ухаж ачсаны дараа автотээврээр баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдрийн агуулахад хүргэн буулгана.

Хүснэгт 1-2. Ил уурхайн процессын дараалал

Үзүүлэлт		Бутлалт	Экскаваци	Тээвэр	Овоолго
Хөрс хуулалт	Шимт хөрс	Байхгүй	Бульдозер Дугуйт ачигч	Бульдозер Автосамосвал	Бульдозер
	Үндсэн хөрс	Өрмийн машин, тэсрэх материал	Экскаватор	Автосамосвал	Бульдозер
Хүдэр олборлолт		Өрмийн машин, тэсрэх материал	Экскаватор	Автосамосвал	Дугуйт ачигч

1.4.2 Тэсэлгээний ажил

Ил уурхайн тэсэлгээний ажлыг гэрээт тусгай зөвшөөрөлтэй компаниар гүйцэтгүүлэх ба тэсэлгээний ажилд өдөөгч ТБ, цооногийн болон гадаргуугийн удаашруулагч, нонель гуурс зэрэг тэсрэх хэрэгслүүд ашиглана. Тэсрэх бодисын хувьд энгийн тэсрэх бодис болон устай цооногуудад эмульсийн тэсрэх бодис хэрэглэнэ.

Тэсэлгээний үед чулуулгийн шидэлт хүнд нөлөөлөх аюултай бүсийн радиусыг 439 м, агаарын цохилтын долгион хүнд нөлөөлөх аюултай бүсийг 220 м, барилга байгууламжид нөлөөлөх аюултай бүсийг 321 м байхаар тус тус тооцсон байна. Иймд тэсэлгээний ажлыг гүйцэтгэхдээ дээрх аюулгүйн бүсийг тогтоож, хүн болон техник хэрэгслийг бүсээс бүрэн гаргах, нэвтрэх хөдөлгөөнийг түр хугацаанд хязгаарлах, анхааруулах дохио, тэмдэг тэмдэглэгээ болон харуул хамгаалалтыг зохих журмын дагуу байршуулж ажиллана.

1.4.3 Үйлдвэрлэлийн нөөц хаягдал, бохирдол

Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн уурхайн ашиглалтын үеийн хаягдал бохирдлын хувийг 2025 онд Эрдэс Баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан ТЭЗҮ-ийн тодотголд

тусгагдсан үзүүлэлтээр Ашиглалтын үеийн хаягдлыг 4.82%, Ашиглалтын үеийн бохирдлыг 4.16% аар авч тооцсон. Уулын ажлын төлөвлөлтөөр 2025 онд Ia хүдрийн судлын В-1, В-2, В-3, блокууд ашиглалтад өртөхөө байгаа ба тухайн блокуудын үйлдвэрийн нөөцийн мэдээллийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-3. 2026 онд ашиглалтад өртөх үйлдвэрлэлийн нөөцийн блокууд


Блокийн дугаар	2025.01.01-ний өдрийн үлдэгдэл нөөц				Ашиглалтын бохирдол		Ашиглалтын хаягдал		Үйлдвэрлэлийн нөөц	
	Эзлэхүүн, м³	Хүдрийн нөөц, тн	Fe, %	Металлын нөөц, тн	%	Хэмжээ, тн	%	тн	Хэмжээ	Fe, %
В-1	74,862	276,988	32.11	88.94	4.16	11,522.70	4.82	13,350.8	275,159.88	30.78
В-2	36,328	134,415	28.11	49.61	4.16	5,591.66	4.82	6,478.8	133,527.86	26.93
В-3	13,746	50,860	31.32	15.93	4.16	2,115.78	4.82	2,451.4	50,524.32	30.01
Нийт	462,263	462,263	30.50	154.48	4.16	19,230.14	4.82	22,281.0	459,212.06	29.24

1.4.4 2026 оны уулын ажлын төлөвлөлт

Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн ордыг ашиглаж эхлээгүй байгаа 2026 оны 7 дугаар сарын хүртэл бэлтгэл ажлыг хангаж уурхайгаа эхлүүлэхээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан. Уурхайгаас 2026 онд 980-1015 түвшинд ашиглалтын үйл ажиллагаа явуулж 866.9 мян.м³ хөрс хуулж, 500 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн.

Хүснэгт 1-4. 2026 оны уулын ажлын төлөвлөлт


№	Үзүүлэлт	7	8	9	10	11	12	Нийт
Уулын ажлын төлөвлөлт								
1	Хөрс хуулалт	144.5	144.5	144.5	144.5	144.5	144.5	866.9
2	Хүдэр олборлолт	83.33	83.33	83.33	83.33	83.33	83.33	500
3	Хөрс хуулалтын дундаж коэффициент	1.73	1.73	1.73	1.73	1.73	1.73	1.73
4	Уулын цул	167.0	167.0	167.0	167.0	167.0	167.0	1368.6
5	Өрөмдлөгийн хэмжээ	6680	6680	6680	6680	6680	6680	6680
6	Тэслэгдэх уулын цул	133.6	133.6	133.6	133.6	133.6	133.6	1094.9




Зураг 1-1. 2026 оны эцсийн байдал

1.4.5 Техник, тоног төхөөрөмж зохион байгуулалт


Хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлэхээр төсөлд тусгасан. Иймд уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг ТЭЗҮ тусгагдсаны дагуу өрөмдлөгийн ажилд Sandvik D1650I маркийн өрмийн машин, тэсэлгээний ажилд АНФО, Эмульсийн тэсрэх бодис, ухаж ачих ажил CAT-374 маркийн экскаватор, хүдэр тээвэрт МТ-86 маркийн автосамосвал, овоолгын ажилд CAT-D8R бульдозер ашиглахаар төлөвлөсөн.



Зураг 1-2. Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт



Зураг 1-3. Ухаж ачих ажлын паспорт




Зураг 1-4. Технологийн замын паспорт

1.5 ХҮДЭР БОЛОВСРУУЛАЛТ, БАЯЖМАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

1.5.1 Баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөө

ТЭЗҮ-д тусгагдсанаар баяжуулах үйлдвэр нь ердийн жилд 329 хоног үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдсөн. Харин эхний жилд буюу 2026 онд 166 хоног ажиллаж, уурхайгаас 500 мян.тн хүдэр олборлож хуурай соронзон баяжуулах технологиор боловсруулах ба Fe-52%-ийн агуулгатай 194.1 мян.тн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөсөн. Технологийн туршилтын тайлан болон технологийн схемээр металл авалт 64%, гарц 35.2%-тай байх ба 16.1% дундаж агуулгатай 356.9 мян.тн хуурай хаягдал үүсэхээр байна. Хуурай соронзон баяжуулах үйлдвэр нь 2 шатны бутлуур, үндсэн хуурай

соронзон баяжуулалт, 1 шатлалт цэвэрлэгээний соронзон баяжуулалт гэсэн дараалалтай явагдана.



Зураг 1-5. Хуурайн соронзон баяжуулах технологийн схем

1.5.2 Хуурай соронзон баяжуулах үйлдвэрийн техник тоног төхөөрөмж

Хуурай соронзон баяжуулах үйлдвэр нь Хүлээн авах бункер-Чичиргээт тэжээгүүр-Хацарт бутлуур-Конусан бутлуур-Шигшүүр-Үндсэн соронзон сеператор-Цэвэрлэгээний соронзон сеператор-ялгалтын конвейер гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.


№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ш	Хүчин чадал, тн/цаг
1	Хүлээн авах бункер		1	
2	Чичиргээт тэжээгүүр	ZSW380x95	1	96-180
3	Хацарт бутлуур	PE 600x900	1	56-192
4	Конусан бутлуур	PYZ 1750/215	1	175-320
5	Шигшүүр	2YA1536	1	100-350
6	Үндсэн соронзон сеператор	CTGG-1018	1	≤270
7	Цэвэрлэгээний соронзон сеператор	CTGG-0814	1	≤120
8	Конвейер		3	800мм
9	Конвейер		5	500мм

1.6 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Уурхайн гадаргуун ерөнхий төлөвлөлтөд дараах барилга байгууламжууд байна. Үүнд:

- **Уурхайн хэсэг:** Ил уурхай, хөрсний гадаад овоолго, шимт хөрсний овоолго, ил уурхайн технологийн зам, талбай.
- **Баяжуулалтын хэсэг:** Баяжуулалтын тоног төхөөрөмжүүд, хүдэр, баяжмал болон хаягдлын овоолгууд, технологийн зам, талбай.
- **Барилга, байгууламжууд:**
 - **Үйлдвэрлэлийн зориулалттай:** Тэсрэх материалын агуулах, засварын талбай, лабораторийн барилга, түлшний агуулах, түгээх станц, гаалийн талбай, автопүү, салхинаас хамгаалах хаалт.

- **Иргэний зориулалттай:** Оффисын байр, ажиллагсдын амрах байр, гал тогоо, хоолны газар, хүнсний агуулахууд, ариун цэвэр, угаалгын байр, спорт болон нийтийн арга хэмжээ зохион байгуулах заал, ундны худаг, хүлгийн байр, харуулын байр, хамгаалалтын далан, шуудуу, галын аюулаас хамгаалах зурвас.
- **Дэд бүтцийн байгууламжууд:** Цахилгаан хангамж, усан хангамж, дулаан хангамж.



Зураг 1-6. Уурхайн гадаргуун ерөнхий төлөвлөлтийн зураг

1.6.1 Ил уурхайн байгууламж

Уурхайн үндсэн байгууламжид хоёр ил уурхай, хөрсний гадаад болон шимт хөрсний овоолго, технологийн зам, талбай хамаарна.

Төслийн 12 жилийн ашиглалтын эцэст 1-р ил уурхай 830 м урт, 370 м өргөн, 180 м гүн, 23.45 га талбайтай; 2-р ил уурхай 370 м урт, 315 м өргөн, 140 м гүн, 9.32 га талбайтай байна.

Хөрсний гадаад овоолгыг 56.35 га, шимт хөрсний овоолгыг 4.38 га талбайд байгуулахаар төлөвлөсөн.

1.6.2 Овоолго

1.6.2.1 Шимт хөрсний овоолго

Төслийн 12 жилийн хугацаанд уурхай болон холбогдох байгууламжийн үйл ажиллагаанд өртөх нийт 109.5 га талбайн шимт хөрсийг 0.2 м зузаантай хуулж, 218.94 мянган м³ хөрс хуримтлуулахаар төлөвлөсөн. Үүнд ил уурхайн 32.77 га, гадаад овоолго болон бусад байгууламжийн 76.7 га талбай хамрагдана.

Хуулсан шимт хөрсийг тусгай овоолгод стандартын дагуу хадгалж, ашиглалтын явцад болон уурхайн хаалтын үеийн техникийн ба биологийн нөхөн сэргээлтэд ашиглана.

1.6.2.2 Хөрсний овоолго

Ордын ашиглалтын явцад үүсэх хөрсийг тээвэрлэлтийн зардал, ашиглалтын нийт хугацаанд шаардагдах багтаамж болон тэлэх боломжийг харгалзан ил уурхайн баруун урд талд, 350 м зайд байрлах гадаад овоолгод байршуулахаар төлөвлөсөн.

Овоолгыг тус бүр 15 м өндөртэй хоёр үеэр байгуулж, нийт 30 м өндөртэйгээр бульдозероор захлан хэлбэржүүлнэ. Тус овоолгод сийрэгжүүлсэн төлөвөөр нийт 22.54 сая м³ хөрс байршуулна.

2023 оны байдлаар хуучин гадаад овоолгод хуримтлагдсан 35.3 мянган м³ хөрс нь ил уурхайн ашиглалтын хүрээнд өртөх тул шинэ гадаад овоолгод шилжүүлэн байршуулна.

1.6.3 Зам тээвэр

Уурхайн технологийн замын сүлжээ нь дотоод болон магистрал замаас бүрдэх бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээтэй байна. Дотоод технологийн замаар ил уурхай, баяжуулах үйлдвэр, шимт хөрс болон хөрсний овоолго хооронд хөрс, хүдэр тээвэрлэнэ.

Хөрс, хүдэр тээвэрлэх замыг хоёр урсгалтай, 15 м өргөн; хотхон, оффис болон тэсрэх материалын агуулахын замыг хоёр урсгалтай, 10 м өргөн байхаар төлөвлөсөн. Уурхайн зам нь нэг талын налуу болон мөргөцгийн замаас бүрдэх бөгөөд уулзвар, эргэлтийн хэсгийг шаардлагатай тохиолдолд түр буулгах талбай болгон ашиглана.

Технологийн замын үндсэн үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн.

Хүснэгт 1-5. Технологийн замын үндсэн үзүүлэлт

№	Замын нэр	Урсгалын тоо	Өргөн, м	Урт, м
1.	Уурхайн зам	2	15	2,600
2.	Шимт хөрсний овоолгын тээврийн зам	2	15	620
3.	Хөрсний овоолгын тээврийн зам	2	15	590
4.	Баяжуулах үйлдвэрийн зам	2	15	1,620
5.	Тэсрэх материалын агуулахын зам	2	10	2,300
6.	Гаалийн хяналтын талбайн зам	2	15	300
7.	Хотхон, оффисын зам	2	10	1,600
Нийт, км				9.63

1.6.3.1 Дотоод тээвэр

Хөрс болон хүдэр тээвэрлэх зай нь уурхайн ашиглалтын үе шат, уулын ажлын фронтын шилжилтээс шалтгаалан жил бүр өөрчлөгдөнө. 2026 онд хөрс тээвэрлэх дундаж зай 0.9 км, хүдэр тээвэрлэх дундаж зай 1.9 км байхаар төлөвлөсөн.


1.6.3.2 Гадаад тээвэр

Гадаад тээврийг гэрээт компани дараах хоёр үе шаттайгаар гүйцэтгэнэ.

 **Нэгдүгээр үе шат:** Баяжмалын овоолгоос 500 м зайд байрлах гаалийн хяналтын талбай хүртэл 25 тоннын даацтай хоёр автосамосвалаар тээвэрлэнэ. Нэг тээврийн мөчлөг ойролцоогоор 0.3 цаг буюу 18 минут үргэлжилнэ. Хоногийн төлөвлөгөөг биелүүлэхийн тулд нийт 28 орчим рейс хийх бөгөөд нэг автосамосвал хоногт дунджаар 14 рейс гүйцэтгэнэ.

 **Хоёрдугаар үе шат:** Гаалийн хяналтын талбайгаас БНХАУ-ын Рашаант боомт хүртэлх 13 км замд 80 тоннын даацтай чиргүүл бүхий хоёр хүнд даацын

автомашинаар тээвэрлэнэ. Нэг тээврийн мөчлөг дунджаар 3.2 цаг үргэлжлэх бөгөөд хоногт нийт 9 орчим рейс буюу нэг автомашин 4–5 рейс гүйцэтгэнэ.



Зураг 1-7. Гадаад тээвэр

Уурхайн гаалийн хяналтын талбайгаас Монгол Улсын хил хүртэлх 8 км замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн бөгөөд төслийн гурав дахь жилд ашиглалтад оруулна. Тус зам ашиглалтад орох хүртэл одоо байгаа сайжруулсан шороон замаар тээвэрлэлт хийж, цаашид уг замыг хатуу хучилттай замын далан болгон ашиглана.

1.6.4 Тэсрэх материалын агуулах

Тэсрэх материалын агуулахыг уурхайгаас баруун урагш 2.6 км зайд байгуулахаар төлөвлөсөн. Агуулах нь уурхайн нэг сарын хэрэглээг хадгалах хүчин чадалтай байна. Тэсрэх бодисыг тус бүр 40 тоннын багтаамжтай 4 контейнерт, тэсрэх хэрэгслийг тус бүр 20 тоннын багтаамжтай 2 контейнерт хадгална. Агуулахыг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн харуул хамгаалалт, хашаа бүхий байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 1-6. Тэсрэх материалын агуулахын үзүүлэлт

№	Тэсрэх материалын төрөл	Тоо, ширхэг	Тэсрэх бодисын хэмжээ, тонн	Чингэлгийн тоо
1	Тэсрэх бодисын агуулах	—	80	4 ширхэг 40 тоннын чингэлэг
2	Тэсэлгээний хэрэгслийн агуулах	50,000	2	2 ширхэг 20 тоннын чингэлэг

Тэсрэх материалын агуулахын багтаамжийг уурхайн нэг сарын хэрэглээг хангах хэмжээгээр тооцсон. Тэсрэх бодисын агуулах нь 80 тонн тэсрэх бодис, тэсрэх хэрэгслийн агуулах нь 50,000 ширхэг хэрэгсэл хадгалах хүчин чадалтай байна.

Төслийн хүрээнд 1.1D ангиллын тэсрэх бодисын нэг агуулах, 1.1В ангиллын тэсрэх хэрэгслийн нэг агуулах буюу нийт хоёр агуулах барихаар төлөвлөсөн.

1.6.5 Засварын газар

Уурхайгаас 600 м зайд 48×28 м хэмжээтэй хүнд машин механизмын засварын газар байгуулахаар төлөвлөсөн. Тус байгууламж нь уулын хүнд машин механизм, тээврийн автосамосвал болон бусад тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ хийх талбай бүхий сэндвичэн барилга байна.

Засварын газрын орчимд авто зогсоол, хогийн цэг болон шаардлагатай бусад туслах байгууламжийг төлөвлөн байгуулна.

1.6.6 Түлшний зөөврийн агуулах, түгээх станц

Зөөврийн 50 м³ багтаамжтай шатахууны агуулах, түгээх станцыг уурхайгаас 550 м зайд байрлуулахаар төлөвлөсөн бөгөөд шатахууныг уурхайн нөхцөлөөр нэмэгдэлгүй үнээр худалдан авна.

Уурхай бүрэн хүчин чадлаар ажиллах үед сард 150–160 мянган литр шатахуун хэрэглэх бөгөөд сард гурван удаа татан авалт хийнэ.

Түгээх станц нь өндөр хурдны цэнэглэх системтэй, 500–1,900 л/мин бүтээмжтэй тоолуур, шатахуун хүлээн авах болон цэнэглэх насос, удирдлага, хяналтын систем, дамарт шланг зэрэг тоног төхөөрөмжөөр тоноглогдоно.

1.6.7 Гаалийн талбай

аяжуулах үйлдвэрээс зүүн тийш 300 м зайд, 1 га талбай бүхий гаалийн хяналтын талбай байгуулахаар төлөвлөсөн. Тус талбайд бүтээгдэхүүн буулгах хэсэг, автопүү болон холбогдох төрийн байгууллагын ажилтнуудын ажиллаж, амрах зориулалттай байр байгуулахаар төлөвлөсөн.

Гаалийн талбай нь 24 цагийн харуул хамгаалалттай бөгөөд гэрэлтүүлэг, камерын хяналтын системээр бүрэн тоноглогдоно.

1.6.8 Автопүү

Гаалийн талбайд 150 тоннын даацтай автопүү байрлуулахаар төлөвлөсөн. Автопүүгээр талбайд нэвтрэх болон гарах тээврийн хэрэгслийн ачааны жинг тодорхойлно.


1.6.9 Чанарын хяналтын лаборатори

Баяжуулах үйлдвэрийн бүсэд төмрийн хүдэр, баяжмал болон хуурай хаягдлын чанарыг тогтмол хянах бага хүчин чадлын лаборатори байгуулна. Лаборатори нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- **Дээж бэлтгэлийн хэсэг:** Дээжийг стандарт аргачлалын дагуу хүлээн авч, хатаах, бутлах, хуваах, нунтаглах, жинлэх замаар шинжилгээнд бэлтгэнэ.
- **Шинжилгээний хэсэг:** Бэлтгэсэн дээжийн төмрийн агуулга, хувийн болон эзлэхүүн жинг химийн болон багажит шинжилгээний аргаар тодорхойлно. Хүхрийн агуулгын шинжилгээг итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор хийлгэнэ.

Лабораторийг агааржуулалт, сорох шүүгээ, усан хангамж, бохир ус цуглуулах байгууламж болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон хоёр зөөврийн сууцаар шийдвэрлэнэ. Шинжилгээнд химийн хорт болон аюултай бодис ашиглах тохиолдолд холбогдох зөвшөөрлийг авч, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөнө.

ТӨМРИЙН ХҮДРИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ПРОЦЕСС



Зураг 1-8. Төмрийн хүдрийн чанарын хяналтын процесс

1.6.10 Ажилчдын амрах байр

Уурхайн хотхоныг ордын баруун хойд хэсэгт 5.8 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Хотхонд стандартын шаардлага хангасан ажилчдын байр, оффис, гал тогоо, хоолны газар, ариун цэврийн байгууламж болон хог хаягдлын цэг байгуулна. Ажилчдын байр, хоолны газар, гал тогоо, ариун цэврийн байгууламжийг дулаалгатай, тохижуулсан 20 болон 40 тоннын контейнероор шийдвэрлэнэ.

Уурхайн оффисыг 40 тоннын дөрвөн контейнер, ажилчдын байрыг 40 тоннын есөн контейнерээр байгуулна. Гал тогоо, хоолны газрыг 100 м² талбай бүхий сэндвичэн барилгаар, ариун цэврийн болон угаалгын хэсгийг 40 тоннын гурван контейнерээр тус тус шийдвэрлэхээр тооцсон.

Гэрээт компаниуд ажилтнуудынхаа ажиллах, амрах байр болон холбогдох байгууламжийг өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

Мөн уурхайн нэгдсэн хурал, олон нийтийн арга хэмжээ, урлаг, спортын үйл ажиллагаа зохион байгуулах зориулалттай 36×24 м хэмжээтэй заал барихаар төлөвлөсөн.

1.6.11 Харуулын байр

Ширэн-Овоогийн уурхайн хотхон, тэсрэх материалын агуулах болон гаалийн хяналтын талбайд тус бүр нэг буюу нийт гурван харуулын байр байгуулна. Харуулын байрыг 20 тоннын контейнероор шийдвэрлэх бөгөөд харуул хамгаалалтын үйлчилгээг гэрээт компаниар гүйцэтгүүлнэ.

1.6.12 Далан шуудуу, галын зурвас байгууламж

Уурхайн хүрээгээр болзошгүй үер, усны аюул болон мал, амьтдаас сэргийлэх зорилгоор нийт 3.5 км урт, 1.5 м өргөн далан, шуудуу байгуулна.

Мөн тус бүс нутагт гарч болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хотхон, оффис, засварын газар, агуулах болон баяжуулах үйлдвэрийн ойролцоо 10–20 м өргөнтэй, нийт 4.6 км урт галын зурвас байгуулна.

1.6.13 Салхинаас хамгаалах хаалт

Салхины нөлөөгөөр тоосжилт үүсэхээс сэргийлэх зорилгоор баяжуулах үйлдвэр, баяжмал болон хаягдлын овоолгын баруун болон хойд талаар 12 м өндөр, 920 м урт салхинаас хамгаалах хаалт байгуулна. Мөн гаалийн талбайн эргэн тойронд 12 м өндөр, 400 м урт хаалт барихаар төлөвлөсөн.

1.7 ДЭД БҮТЭЦ

1.7.1 Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг БНХАУ-аас 10 кВ-ын агаарын шугам татаж шийдвэрлэнэ. Агаарын шугам татах, бууруулах станц байгуулах ажлыг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэж, ашиглалтын гурав дахь жилээс цахилгаан эрчим хүчийг бууруулах станцаар дамжуулан хангахаар төлөвлөсөн.

Ашиглалтын эхний хоёр жилд цахилгаан хангамжийг дизель генераторуудаар шийдвэрлэнэ. Улмаар ашиглалтын гурав дахь жилээс дизель генераторуудыг ослын болон тасалдлын үеийн нөөц эх үүсвэр болгон ашиглана.

1.7.2 Дулаан хангамж

Дулаан хангамжийг цахилгаан хангамжаар шийднэ.

1.7.3 Усан хангамж

Төслийн хүрээнд унд, ахуйн $15.9 \text{ м}^3/\text{хон}$ усны хэрэглээг Дорнод аймаг дахь хилийн боомтын захиргаатай байгуулсан гэрээний дагуу, тоосжилт бууруулах болон ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах $166.0 \text{ м}^3/\text{хон}$ усны хэрэглээг $8.6 \text{ м}^3/\text{сек}$ ($8,600 \text{ м}^3/\text{хон}$) урсацтай Ойгор гол (голын урсцын 0.02 хувийг ашиглана) -оос хангана.

Цаашид төслийн талбай дээр худаг гарган ашиглахаар төлөвлөж байна.

1.8 ТӨСЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаа 2026 оны 7 дугаар сараас эхлэх тул ашиглалтын эхний жилд нийт 184 хоног ажиллаж, 500.0 мянган тонн хүдэр олборлохоор төлөвлөсөн. 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлосон хүдрийг хуурай соронзон баяжуулалтын технологиор боловсруулж, төмрийн 52 хувийн агуулгатай 194.1 мянган тонн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Мөн дараах бтээн байгуулалтыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Ил уурхайн байгууламж
2. Овоолгууд
3. Зам тээвэр
4. Тэсрэх материалын агуулах
5. Засварын газар
6. Түлшний агуулах
7. Гаалийн талбай
8. Автопүү
9. Ажилчдын байр

БҮЛЭГ 2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Монголын дорнод талын их мужид хамаарах бөгөөд гадаргын хувьд нам дор, өргөн уудам тэгш болон ухаа гүвээт тал зонхилно. Уул нуруу бараг байхгүй, хотос хонхор болон намхан гүвээ, сэрвэн цөөн тохиолддог бөгөөд тэдгээрийн харьцах өндөр бага, гадаргын хэлбэр нь ерөнхийдөө мөлгөр, налуу байна.

Тус бүс нутгийн гадаргын үнэмлэх өндөр дунджаар далайн түвшнээс дээш 700–1,000 м бөгөөд Монгол орны дундаж өндөр болох 1,580 м-тэй харьцуулахад нам дор газар нутагт тооцогдоно. Бүс нутгийн хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 586 м өндөрт орших Буйр нуур, хамгийн өндөр цэг нь 1,504.4 м өндөр Соёлз уул юм. Зүүн захын хэсэгт Их Хянганы салбар бэсрэг уулс орших боловч бусад нутагт тэгш талын хэв шинж давамгайлна..

2.2 ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Монголын дорнод талын эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарна. Тус бүс нутаг харьцангуй чийглэг боловч агаарын температурын улирлын хэлбэлзэл их, хур тунадас жигд бус, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, ган, зуд үе үе тохиолддог онцлогтой.

Жилийн дундаж агаарын температур ойролцоогоор 0.6–1.1°C байна. Хамгийн хүйтэн I сарын дундаж температур Халхголд –23.8°C, Матадад –19.4°C, хамгийн дулаан VII сарын дундаж температур +20.0°C орчим байдаг. Хөрсний гадаргын температур зундаа +56–63°C хүрч халдаг бол өвөлдөө –46–47°C хүртэл буурна. Хүйтрэлгүй үе 115–118 хоног, ургамал ургалтын идэвхтэй хугацаа 128–140 хоног үргэлжилдэг.

Жилд дунджаар 220–280 мм хур тунадас ордог бөгөөд нийт хур тунадасны 90 орчим хувь нь IV–IX сард төвлөрнө. Хур тунадасны хэмжээ жил бүр ихээхэн хэлбэлздэг тул ургамлын ургалтыг хязгаарлах гол хүчин зүйл нь чийгийн дутагдал болон зуны хэт халалт юм.

Жилийн дундаж салхины хурд 3–5 м/с, хаврын улиралд 5.0–6.7 м/с хүрч, баруун болон баруун хойд чиглэлийн салхи зонхилно. Хүчтэй салхины хурд 38–40 м/с хүрэх боломжтой бөгөөд жилд 15–20 өдөр 15 м/с-ээс дээш хурдтай салхи ажиглагдана. Хүчтэй салхи ихэвчлэн хаврын улирал болон өдрийн цагаар тохиолддог..

2.3 АГААРЫН ЧАНАР

Төсөл хэрэгжих талбай нь чийглэгдүү, сэрүүвтэр зунтай, хахирдуу өвөлтэй уур амьсгалын мужид хамаарна. Жилд дунджаар 280–300 мм хур тунадас ордог бөгөөд үүний 80 орчим хувь нь VI–VIII сард төвлөрдөг. Цасан бүрхүүл XI–III сарын хооронд тогтож, зарим үед 1 м хүртэл зузаарна. VII сарын дундаж температур +21.8°C, I сарын дундаж температур –23.7°C байна. Жилийн нартай хугацаа 2,800–2,900 цаг, салхины дундаж хурд 3–4.5 м/с бөгөөд хавар, намрын улиралд 15 м/с-ээс давах тохиолдол бий.

Төслийн талбай болон орчны бүсийг төлөөлөх цэгүүдэд агаар дахь хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос болон PM₁₀, PM₄₋₀, PM₂₋₅, PM₁₋₀ тоосонцрын агууламжийг хэмжсэн. Шинжилгээний үр дүнг агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулан үнэлсэн.

SO₂ болон NO₂-ийн сорьцыг Sibata MP-300 багажаар авч, MNS 17.2.5.11, MNS 17.2.5.12 аргачлалын дагуу UNICO 1200 спектрофотометрээр шинжилсэн. Тоос, тоосонцрын агууламжийг лазерын гэрлийн сарнилын зарчимд суурилсан TSI DustTrak 8533 зөөврийн автомат багажаар хэмжиж, хэмжилтийн хугацааны хамгийн бага, их болон дундаж агууламжийг тодорхойлсон.

2.4 ФИЗИК БОХИИРДОЛ

Физик бохирдлын түгээмэл хэлбэрийн нэг нь хүний эрүүл мэнд, тав тухтай орчинд сөргөөр нөлөөлөх хэмжээний дуу шуугиан юм. Орчны дуу шуугианы зөвшөөрөгдөх түвшнийг MNS 4585:2016 стандарт болон холбогдох эрүүл ахуйн шаардлагаар зохицуулдаг. Хэвийн хэмжээнээс хэтэрсэн дуу шуугианд удаан хугацаагаар өртөх нь сонсгол буурах, ядрах, анхаарал сулрах, нойргүйдэх, цусны даралт ихсэх, зүрх судас болон мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Дуу шуугианы үндсэн эх үүсвэрт авто тээвэр, төмөр зам, нисэх онгоц, үйлдвэр, барилга байгууламж, чанга яригч болон ахуйн цахилгаан хэрэгсэл хамаарна. Тухайлбал, автобус 82–89 дБА, төмөр замын хөдөлгөөн 75–80 дБА, нисэх онгоц 100–160 дБА хүртэл дуу шуугиан үүсгэж болдог.

Суурьшлын бүсэд тайван амрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд шөнийн цагт орон сууцны дуу шуугианы түвшнийг 30–35 дБА орчим байлгах нь тохиромжтой. Дуу шуугианы бохирдлыг бууруулахад ногоон байгууламж, хамгаалалтын зурвас байгуулах, тээврийн хөдөлгөөнийг зохицуулах, дуу чимээ ихтэй объектуудыг суурьшлын бүсээс зайдуу төлөвлөх, дуу тусгаарлах байгууламж ашиглах, тогтмол хэмжилт болон хяналт хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5 ГАДАРГЫН УС БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС

Төслийн талбай нь Буйр нуур–Халх голын сав газарт хамаарах бөгөөд орчимд Халх гол, Нөмрөг, Дэгээ зэрэг тогтмол урсацтай гол горхи, нуур тойром, булаг шанд болон түр урсацтай хуурай сайр тархсан. Голуудын урсац цас, мөсний хайлалт болон хур тунадасны нөлөөгөөр хавар, зуны улиралд нэмэгддэг.

Дэгээ голын 2010–2025 оны хэмжилтээр олон жилийн дундаж урсац 8.6 м³/сек байна. Уурхайн унд, ахуйн 15.9 м³/хоног усыг Нөмрөгийн хилийн заставын гүний худгаас зөөврөөр, зам, талбайн тоосжилт бууруулах болон ногоон байгууламжийн усалгааны 166.0 м³/хоног усыг гадаргын усны эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн. Хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах тул технологийн үйл ажиллагаанд ус ашиглахгүй.

Төслийн хүрээнд Усны газраас 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр олгосон Е-2603000028 дугаартай ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр нийт 181.96 м³/хоног ус ашиглахаар тогтоосон бөгөөд уг дүгнэлтийн дагуу ус ашиглалтыг зохион байгуулж ажиллана.

2.6 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн уурхайн 1,745.74 га талбай нь далайн түвшнээс дээш 960–1,290 м өндөрт байрлах бөгөөд нам уул, аараг толгод, өргөн хөндий бүхий гадаргатай. Төслийн талбайд хүрэн болон хар хүрэн хөрсний дэд хэв шинжид хамаарах чулуурхаг, нимгэн, сайргархаг, элсэрхэг, мараалаг хөрс дангаар болон бүрдэл байдлаар тархсан.

Хөрсний шимт үеийн дундаж зузаан 0–30 см, ялзмагийн агууламж 1.5–2.2% бөгөөд үржил шим багаас дунд зэрэг байна. Хөрс нь элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй, бага зэрэг чулуурхаг, дунд ширхэгтэй элсний агууламж өндөр, механик

нөлөөлөлд дунд зэрэг тэсвэртэй боловч байгалийн нөхөн сэргэх чадвар сул. Урвалын орчин нь саармагаас дунд зэрэг шүлтлэг (pH 7.0–8.0), хялбар уусах давсжилт 0.07–1.30 dS/m байна. Хөрсний өнгөн үе дэх хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх хэмжээнээс хэтрээгүй, бохирдлын түвшин хэвийн байна.

2.7 УРГАМЛАН НӨМРӨГ

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдлын хээрийн судалгааг 2025 оны 6 дугаар сарын эхээр хийж, 10×10 м хэмжээтэй талбайд геоботаникийн бүрэн бичиглэл үйлдэн ургамлын зүйлийн бүрдэл, тусгагийн бүрхэц, өндөр, ургац, биомасс болон талхагдлын түвшнийг тодорхойлсон.

Төслийн талбай нь Дорнод Монголын жинхэнэ хээрийн ургамалжилд хамаарах бөгөөд хялгана, ботууль, саман ерхөг зэрэг үетэн болон алаг өвс, сөөгт бүлгэмдэл зонхилно. Судалгааны цэгүүдэд ургамлын тусгагийн бүрхэц 50–95%, дундаж өндөр 15–30 см, ургац 2.2–9.2 ц/га байсан бөгөөд нэг бичиглэлийн талбайд 45–46 зүйл ургамал бүртгэгдсэн. Мөн нам уулын хажуу, бэл хормойд хусан ой, сөөгт бүлгэмдэл, ус чийгтэй хотос хэсгээр намагсаг болон давссуу чийглэг орчны ургамал бага талбайгаар тархсан байна.

Төслийн талбай нь хилийн зурваст байрладаг тул бэлчээрийн ашиглалт харьцангуй бага, ургамлан нөмрөгийн үндсэн хэсэг соргог, талхагдал бага байна. Харин уурхайн талбай, кемп, барилга байгууламж, хайгуулын цооног, хаягдлын сан болон хуучин замын орчим антропоген нөлөөлөлд хүчтэй, түр замын хэсэг дунд зэрэг доройтсон. Эдгээр эвдрэлд өртсөн талбайд байгалийн нөхөн сэргээлт явагдаж, цөөн наст ургамлын оролцоо нэмэгдэж байна.

Судалгаагаар нэн ховор 1, ховор 11, Монгол орны Улаан номд бүртгэлтэй 2, завсрын унаган 4, үлдвэр 3 зүйл ургамал тэмдэглэгдсэн. Иймд газар хөндөх үйл ажиллагааны өмнө ховор болон хамгаалалтад хамрагдах ургамлын байршлыг нарийвчлан тогтоож, хамгаалалт, шилжүүлэн суулгалт болон тогтмол мониторингийн арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

2.8 АМЬТНЫ АЙМАГ

“Ширэн-Овоо” төмрийн хүдрийн уурхайн тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 1,067 км, Чойбалсан хотоос зүүн урагш 448 км, Халхгол сумын төвөөс зүүн урагш 70 км, Сүмбэр боомтоос баруун тийш 10 км зайд, Нөмрөгийн дархан цаазат газраас ойролцоогоор 5 км зайд байрлана. Амьтны газарзүйн мужлалаар Хянганы тойрогт хамаарах бөгөөд ой, ойт хээр, нуга, хээр, голын хөндий хосолсон шилжилтийн экосистемтэй, биологийн олон янз байдлын хувьд онцгой ач холбогдолтой нутаг юм.

Тус бүсийн биологийн олон янз байдлын суурь мэдээлэл харьцангуй хомс тул судалгаанд өмнөх судалгааны бүтээл, хэвлэлийн эх сурвалж, Нөмрөгийн ДЦГ-ын судлаач, байгаль хамгаалагч, хилийн цэрэг болон нутгийн иргэдийн мэдээллийг ашигласан. Нөмрөг, Халх голын сав нутагт 57 зүйл хөхтөн, 251 зүйл шувуу, 24 зүйл загас, 3 зүйл хоёр нутагтан, 5 зүйл мөлхөгч бүртгэгдсэн бөгөөд сээр нуруугүй амьтдын зүйлийн бүртгэл бүрэн хийгдээгүй байна.

Бүс нутагт голын халиу, хандгай, хүрэн баавгай, халиун буга, монгол тарвага, дорнын сармаахай, мануул, шилүүс, саарал чоно, цагаан зээр зэрэг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хамгааллын ач холбогдолтой амьтад тархдаг. Мөн их тоодог, цагаан хүзүүт тогоруу зэрэг ховор шувууд тохиолдох бөгөөд Халх голын сав газар нь усны болон нүүдлийн шувуудын чухал амьдрах орчин болдог. Амьдрах орчны хувьд голын хөндийд хамгийн олон буюу 41 зүйл хөхтөн бүртгэгдсэн бол уулын хээрт 29, хусан ойд 16, нарсан төгөлд 11 зүйл тэмдэглэгджээ.



Цагаан зээр нь Дорнод Монголын тал хээрийн экосистемийн зонхилох туруутан бөгөөд хур тунадас, ургамлын ургац, бэлчээрийн нөхцөлийг даган улирлын болон нөхцөлт шилжилт хөдөлгөөн хийдэг. Дэлхийн цагаан зээрийн тархац нутгийн 92.9% нь Монгол Улсад ногдох бөгөөд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн тал хээрт дэлхийн хамгийн том үргэлжилсэн популяци байршдаг. Баянцагааны тал, Жаран Тогоо “А” тусгай хамгаалалттай газар болон тэдгээрийн хоорондох Хөөврийн хар овоо, Буян овоо зэрэг орон нутгийн хамгаалалттай газар нь цагаан зээрийн шилжилт хөдөлгөөний чухал холбоос нутагт тооцогдоно.

2.9 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дорнод аймаг. Нийслэлээс зүүн хязгаарт орших Дорнод аймаг нь засаг захиргааны хувьд Баян-Уул, Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Дашбалбар, Матад, Сэргэлэн, Халхгол, Хэрлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Хөлөнбуйр гэсэн 14 сум, 67 багтай. Дорнод аймагт 24,000 гаруй өрхийн 84,000 орчим хүн оршин сууж байна. Аймгийн хүн амын тоо сүүлийн жилүүдэд тогтвортой өсөх хандлагатай байгаа бөгөөд нийт хүн амын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа жигд хуваарилагдсан байна.

Халхгол сум. Дорнод аймгийн 14 сумын нэг нь Халхгол сум юм. Халхгол сум нь засаг захиргааны 3 багтай (1-р баг буюу Ялалт, 2-р баг буюу Тамсагбулаг, 3-р баг буюу Ташгай) бөгөөд төслийн талбай нь 1-р багт хамаарагдана. Халхгол суманд 1,000 орчим өрхийн 3,200 гаруй хүн оршин сууж байна. Сумын хүн амын тоо сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хүйсийн харьцааны хувьд эрэгтэй, эмэгтэй иргэдийн эзлэх хувь ойролцоо түвшинд байна.

1-р баг (Ялалт баг). Халхгол сумын 1-р багт 400 орчим өрхийн 1,400 гаруй хүн оршин сууж байна. Багийн хүн амын тоо сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байна. Багийн нийт хүн амын эрэгтэй болон эмэгтэй иргэдийн эзлэх хувь тэнцвэртэй байдлаа хадгалж байна.

БҮЛЭГ 3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАР

- Уурхайн тээврийн хэрэгслээс ялгарах азотын ислүүдийн жилийн дундаж агууламж уурхайн тээвэрлэлт олборлолт явагдаж байгаа хэсэгт 25-30 мкг/м³ агууламжтайгаар тархах боломжтой.
- Ордын олборлох тээвэрлэх үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны агууламж олборлолт хийгдэж байгаа бүсийн дундаж агууламж 250 мкг/м³ буюу стандартаас 2.5 дахин PM₁₀ тоосонцрын агууламж 100 мкг/м³ буюу стандартаас 2.0 дахин давж орчны агууламжийг нэмэгдүүлнэ PM_{2.5} тоосны агууламж 20 мкг/м³ буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 15 мкг/м³ агууламжаас 1.2 дахин давах боломжтой байна. Уурхайн нийт үйл ажиллагаанаас орчны агаарын чанарт нөлөөлөх бүсийн хэмжээ уурхай орчмын 2650 га талбайг хамарч байна.
- ТЭЗҮ-ийн тодотголд тусгаснаар төслийн хугацаанд нийт 19.8 сая литр дизель түлш хэрэглэхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс ойролцоогоор 53.1 мянган тн CO₂ ялгарах тооцоотой байна.
- Ахуйн хог хаягдлаас NMVOC, TSP, PM_{2.5}, PM₁₀ үүсэж болзошгүй.
- Талбай чөлөөлөлт, ухалт, тэгшилгээний үед үүсэх тоосжилт
- Барилгын материал, тоног төхөөрөмж тээвэрлэлтийн явцад дэгдэх замын тоос
- Барилга угсралтын техник, тоног төхөөрөмжийн шаталтаас үүсэх NO_x, CO зэрэг хий
- Салхи ихтэй, хуурай нөхцөлд тоос дэгдэх давтамж нэмэгдэх
- Хүнд даацын тээврийн хэрэгслийн тогтмол хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт
- Тоног төхөөрөмжийн шаталтаас ялгарах шаталтын хий
- Ил задгай талбай, зам талбайгаас дэгдэх хоёрдогч тоосжилт

3.2 УСАН ОРЧИН

- Төслийн ажилчдын унд ахуйн хэрэглээнд хоногт 15.9 м³ усыг гүний уснаас хангана.
- Тоосжилт, зам талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд хоногт 166 м³ усыг гадаргын уснаас хангана.
- Ус татах, дамжуулах байгууламжийн орчимд орон нутгийн шинжтэй физик өөрчлөлт үүсэх
- Ус таталтын үед усны түр зуурын булингаржилт нэмэгдэх.

3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ

- Хөрсний механик эвдрэл, нягтшил;
- Үржил шимт давхаргын алдагдал;
- Хөрсний элэгдэл, бутрал;
- Түлш, тос, тосолгооны материалтай холбоотой бохирдол;
- Түр болон байнгын овоолгоос үүдэх хөрсний дарагдал.

3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

- Ургамлын бүрхэвч шууд устах, талбайгаар хорогдох;
- Ургамлын үндэс, иш механикаар гэмтэх;
- Тоосжилтын нөлөөгөөр навч, иш бохирдож фотосинтез буурах
- Ургамлын амьдрах орчин бутарч тасрах;

- Зарим зүйлийн тархалт хумигдах.
- Амьтдын амьдрах орчин багасах, бутарч тасрах;
- Дуу чимээ, тэсэлгээ, техник хөдөлгөөнөөс шалтгаалсан дайжилт, үргээлт;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэх мөргөлдөх эрсдэл;
- Тоосжилт, хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан идэш тэжээлийн нөхцөл доройтох;
- Шөнийн гэрэлтүүлгээс шалтгаалсан шувуудын зан үйлийн өөрчлөлт.

3.5 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ

- Тус үйлдвэр ашиглалтад орсноор нийт 133 байнгын ажлын байр бий болно.
- Төслийн хугацаанд 4.13 тэрбум төгрөгийн татварыг улсын болон орон нутагт төлнө.
- Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр аж үйлдвэрийн төвлөрлийг бий болгож цаашид аж үйлдвэрийн салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системийн (ТБЭХС) хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.
- Metallургын коксын үйлдвэрээс ялгарах хаягдал утаагаар цахилгаан эрчим хүч үйлдвэрлэснээр төслийн өгөөжийг нэмэгдүүлэхээс гадна коксын үйлдвэрийн байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгана.
- Багахангай дүүрэгтэй хамтын ажиллагааны хүрээнд төсөл хөтөлбөрүүдэд хувь нэмэр оруулах.
- Төсөл хэрэгжсэнээр Багахангай дүүрэгт хүн амын төвлөрөл нэмэгдэх, төслөөс үүдэлтэй дуу шуугиан, тоос, агаарын бохирдол, хөл хөдөлгөөн зэрэг ихсэж орон нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Төсөл хэрэгжсэнээр дүүргийн хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж төрийн үйлчилгээний (эмнэлэг, цагдаагийн алба, сургууль, цэцэрлэг гэх мэт) ачаалал нэмэгдэх, хомсдол үүсэж болзошгүй.

БҮЛЭГ 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

ЗОРИЛГО, ЗОРИЛТ

“Талын Эрдэс” ХХК-ийн Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших MV-020902 “Ширэн-Овоо” нэртэй Төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2026 онд “Грийн солюшн консалтинг” ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж, байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөөг мөрдлөг болгон Монгол Улсын байгаль орчны багц хууль, дүрэм журам, стандартуудыг шаардлагыг биелүүлж, төслөөс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллүүдийг арилгах, бууруулах зорилгоор энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон төслийн барилга угсралтын үеийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг тооцлоо.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

“Ширэн-Овоо” нэртэй Төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2026 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд 177,260,500 төгрөг зарцуулахаар байна.

Хүснэгт 4-1. 2026 оны БОМТ-ын зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2026 он (төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22,400,000
2	Нөхөн сэргээлт	53,400,000
3	Тэрбум мод	16,600,000
4	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	52,164,500
5	Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	6,000,000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,500,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,800,000
8	Удирдлага, зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,600,000
9	Байгаль орчны төлөвлөгөөт аудит	10,000,000
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,796,000
	Нийт зардал	177,260,500

4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ширэн-Овоон бэлтгэл үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин, биологийн олон янз байдалд үзүүлж болзошгүй 16 сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах 20 арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт 4-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

